



АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТОВЧ ТАЙЛАН

2022.01.26


Алтайн зам ХК нь 1935 онд үүсгэн байгуулагдаж, 1999 оноос хойш хувьцаат компанийн зохион байгуулалттайгаар өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж буй Биржид бүртгэлтэй ууган компаниудын нэг.

Монгол Улмын нийгэм эдийн засаг болоод бизнесийн орчны нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагааны чиглэлийг амжилттайгаар өөрчлөн явуулж байна.

Бид үйл ажиллагаагаа нээлттэй ил тод байдлаар хуульд нийцүүлэн явуулдаг ба энэ талаарх тайлан мэдээг тухай бүр Хороо болон Биржид тайлагнасаар ирсэн.

2022 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан

Алтайн зам ХК нь 2022 онд дараах бүтэцтэйгээр, ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр болон хууль тогтоомжийн хүрээнд ажиллаа.



Санхүүгийн алба

Төслийн алба

Инженер техникийн

Хүний нөөцийн алба

- 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолд нийцүүлэн 2022 оны 03 сарын 28-ны



- өдөр товлож, үнэт цаасны үйлчилгээ үзүүлэгч 11 компаниуд болон Хороо Биржид мэдэгдэж амжилттай зохион байгууллаа.
- Алтайн зам ХК-ийн нийт 54,154 ширхэг хувьцаа нь үнэт цаас, брокерын үйлчилгээ үзүүлэгч 11 компанид бүртгэлтэй байдаг нийт хувьцаа эзэмшигчдийг ээлжит хуралдаанд оролцох бүхий л нөхцөлөөр ханган ажилласан ба цар тахлын тархалттай холбоотойгоор хуралдааныг онлайнар хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж дараах асуудлыг танилцуулан шийдвэрлүүлсэн байна.
 - 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн дүгнэлт хэлэлцэх
 - 2021 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг дүгнэх
 - ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах
 - Улсын бүртгэлийн бүртгэлд хувьцааны тоо зөрүүтэй бүртгэгдсэнийг залруулах
 - Хорооноос 2022 оны 04 сард 144 дүгээр тогтоолоор Компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөх зөвлөмж хүргүүлсний дагуу засаглалын кодексын үнэлгээний тайланг хагас жилийн байдлаар Хороо болон Биржид хүргүүлсэн.
 - Мөн Засаглалын кодексыг шинэчлэн баталсантай холбогдуулан 2021 онд баталсан Кодексыг үл тохирол байгаа эсэхийг ажлын хэсэг гарган хянуулсан ба ямар нэг үл тохирол байгааг, үй тул үйл ажиллагаандаа хэвийн мөрдөж байна.
 - Хорооноос 2022 оны 145 дугаар тогтоолоор Компанийн засаглалын кодексыг шинэчлэн баталсантай холбогдуулан Ёс зүйн дүрэм, Гүйцэтгэлийн үнэлгээний журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам, Хөдөлмөрийн дотоод журмуудыг шинэчлэн баталж мөрдөж эхлээд байна. Энэ талаарх мэдээллийг үнэлгээний тайланд зүйл заалтаар нь тусгайлан зааж олон нийтэд нээлттэй байдлаар танилцуулж байгаа болно
 - Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хүний дахин давтагдашгүй биометрийн өгөгдөлд суурилсан төхөөрөмжүүдийг үйл ажиллагаанд ямар ч байдлаар ашиглахыг хориглосон ба мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор үйл ажиллагаандаа ISO27001 мэдээллийн аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэхээр бэлтгэлийг хангаж мэдээллийн урсгал, мэдээллийг өмчийн эздийг тодорхойлоод байна.
 - Бид үйл ажиллагаандаа баримтлах алсын хараагаа тодорхойлж, дунд хугацааны стратегиа төлөвлөж, үүний хүрээнд ERP системийг үйл ажиллагааг хэвийн тасралтгүй байлгаж, нэг ажилтны өгөөжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин хөлсний бодлогыг батлан мөрдөж эхлээд байна.

Санхүү, эрсдэлийн удирдлагын хүрээнд хийсэн ажлууд

- Дэлхийн банк болон олон улсын сангаас зүгээс 2023 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.2 хувь гэж тооцоолж байсан бол 2023 он гарсаар уг



төсөөллийг 1.7 хувь гэж тооцоолж танилцуулсан. Өөрөөр хэлбэл цар тахлын нөлөөлөл болон ОХУ, Украины дайны байдлын нөлөөлөл 2023 онд үргэлжилнэ гэдгийг хүлээн зөвшөөрөөд байна. Өнгөрөгч 2022 онд бид хорио цээрийн дэглэмийн горимоор ажилласан ба хил, гаалийн нөхцөл байдал болон өвчний тархалтын хэмжээнээс хамаарч төлөвлөн ажиллах боломжгүй нөхцөлд менежментийн зохистой аргыг сонгон хэрэглэж ажиллаа.

- Хэдийгээр дэлхий нийтээр цар тахлын хорио цээрийн дэглэж мөрдөж, хязгаарлалтын горимоор ажиллаж байсан боловч ажиллах хүчийг тогтоон барихад онцгой анхаарч ажиллаа.
- Түүнчлэн өөрсдөөс үл хамаарах эрсдэлт нөхцөл байдал тохиолдсон үед ажиллах төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлагын чиг үүргийг байнгын ажиллагаатай ДАГ-ын үндсэн чиг үүрэгт оруулан ажиллаж байна.
- Түүнчлэн бид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, стратеги төлөвлөгөөндөө хүрэх, чанарыг эрхэмлэсэн хамт олон болохын төлөө 2023 онд нэмэлт хувьцаа гаргахаар төслийг бэлтгэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.
- Санхүүгийн үйл ажиллагаанд улирал бүр ДАГ-с аудит хийж, илэрсэн зөрчлийг арилгах талаар арга зүйн зааварчилгааг тухай бүр авч ажиллаа.
- Хөндлөнгийн аудитын байгууллагын сонгон шалгаруулахдаа Хорооноос зөвшөөрөл авсан аудитын байгууллагыг сонгож ТУЗ-р хэлэлцүүлэн батлуулж ажилладаг ба дүгнэлтийн дагуу гарсан зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
- Аудитын хорооны дэргэдэх байнгын ажиллагаатай ДАГ-аас 2022 оны эхний хагас жилд хийсэн дүгнэлтийг Хороонд хүргүүлсэн ба жилийн эцсийн дүгнэлт 2023 оны 2 сарын 20-д гаргахаар ажиллаж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2023.01.26

Алтай Зам ХК нь 2022 онд ТУЗ-ийн 9 гишүүнтэйгээр аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороод болон байнгын ажиллагаатай дотоод аудитын газар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаа.

Гишүүд	Статус
М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга
С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн
С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн
С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн
Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн
Г.Сономжамц	Хараат бус гишүүн
Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн
Б.Бат-Ирээдүй	Хараат бус гишүүн
Т.Мөнгөнцацрал	Хараат бус гишүүн
Б.Буянзаяа	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ-ийн зүгээс 2021 онд Компанийн засаглалын кодекс болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ёс зүйн дүрэм, Сонирхлын болон их хэмжээний хэлцэл хийх журам, ДАГ-ын журмыг батлан мөрдүүлж ажилласан ба Хорооны зүгээс Компанийн засаглалын кодексыг шинэчлэн баталсантай холбогдуулан засаглалын үйл ажиллагаанд хэд хэдэн зарчмыг нэмж бодлого боловсруулан баталж 2023 оны 01 сарын 1-с эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж байна.


ТУЗ-ийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн гишүүдийг бүрэн хамруулах, гүйцэтгэх удирдлагаас гаргаж буй санал санаачилгыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.

- ТУЗ-ийн үндсэн үйл ажиллагаа болох хурлыг тогтмолжуулж 2022 онд нийт 36 удаа хуралдаж 166 тогтоол гаргаж ажиллаа.
- Хуралдааныг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нөхцөлөөр хэлэлцэх асуудлын талаарх мэдээ мэдээллийг бэлтгэн ТУЗ-ийн гишүүд рүү цахим шуудан болон дотоод форумар дамжуулан илгээн танилцуулж ажилласан.
- ТУЗ-ийн гишүүдийн хуралдааны ирцэд онцгой анхаарч, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар хуралдааныг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж ажилласан ба хуралдааныг 100 хувийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулсан.



- ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг аливаа ажил үүрэг хавсран гүйцэтгүүлэхгүй байх үндсэн зарчмыг баримталж журмыг чанд мөрдсөн
- Хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх, хараат бус гишүүд бие даасан байдлаар ажиллах нөхцөлийг хангах зорилгоор ирцийн тодорхой урамшууллыг олгох саналыг цалин урамшууллын хорооноос гаргасныг Хувьцаа эзэмшигчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.
- ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын багтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан аливаа шийдвэрийг гаргахаас өмнө Гүйцэтгэх удирдлагын багаас санал, тайлбарыг авч ажиллаа.
- Бид үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг аюулгүй нөхцөлөөр ашиглах зорилтын үр дүнд Компанийн ямар ч ажилтан зөрчлийн талаарх мэдээ мэдээллийг ТУЗ-ийн аль ч гишүүнд шууд хандан гаргах боломжийг дотоод сүлжээндээ байршуулсан ба тухайн гаргасан гомдол, санал хүсэлт зөвхөн хаяглагдсан этгээдэд нээлттэй байхаар тохируулга хийгдсэн.
- Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартыг нэвтрүүлэхээр зөвлөх компанийг сонгож, нэвтрүүлэлтийн шатандаа явж байна.
- Компанийн ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх, дотоод нөөц бололцоог сайжруулах зорилгоор ERP системийг бүрэн нэвтрүүлсэн ба үүнд ТУЗ-ийн зүгээс тогтмол хяналтыг хэрэгжүүлсэн.
- ТУЗ-ийн дэргэдэх байнгын ажиллагаатай ДАГ-ын үндсэн чиг үүрэгт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлийг нэмсэн
- Цалин урамшууллын бодлогыг гүйцэтгэлийн удирдлагатай нягт уялдуулж бүтээмжийг нэмэгдүүлэх тал дээр онцгойлон анхаарч гүйцэтгэлийн удирдлагын журам болон цалин урамшууллын журмыг шинэчлэн баталсан.
- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудыг үнэн зөв мэдээллээр тухай бүр хангах зорилгоор мэдээллийн урсгалын тогтолцоог нэвтрүүлж, оролцогч талуудад үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг шуурхай хүргэн ажиллаа.

Тогтоолын задаргаа



■ Зээл хүссэн тогтоол

■ Хөрөнгө барьцаалах тогтоол

■ Засаглалын үйл ажиллагаатай холбоотой тогтоол

■ Бусад